



Санхүү Эдийн засгийн Дээд Сургууль

Авилгалтай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь

Гүйцэтгэсэн : /...../М.Алтан-Од /БУ/III Курс

Улаанбаатар хот 2011 он

Агуулга

- Оршил хэсэг
- Үндсэн хэсэг
- Судалгааны хэсэг
- Дүгнэлт хэсэг

“Оршил хэсэг”

Өнөөгийн нийгмийн үнэт зүйлс байх ёстой шударга ёс нь Монгол улсын хувьд байх ёстой тодорхой хэм хэмжээгээ алдан суларсаар байгааг та бид мэдэх билээ.Авилгал гэгч тухайлбал хүний янз бүрийн хэрэгцээн дээр тулгуурлан гарч энгийнээр бол нийгмийн хуулийн дагуу үйлчлэх ёстой журмыг зөрчин өөрсдийн ашиг сонирхлын үүдэн дээрээс хоёр болон түүнээс дээш этгээдийншударга бусаар хэрэгцээгээ хангах үйл явц юм.

Ардчилсан нийгэмд эрх ба үүргийн харилцан хамаарлыг ухамсарлаагүйгээс эсвэл хэт их хүнд суртал ,ядуурал гэх мэт олон хүчин зүйлсээс улбаадан энэхүү авилгал гээч нь үүсдэг билээ.Авилгийн индексийн үзүүлэлтээрээ хэт их дээгүүр байр эзэлж буй улсууд тухайн улсын төр засаглал болохгүйг илтгэдэг хэмээдэг.Ийм ч учраас ихээхэн судлаачид иргэд болон төрийн байгуулсан засаглалын үр шимийг хомслогч шударга бусаар залилагчдийг нийгмээс гаргахгүй бол таагүй үр дүн гардгийг сануулдаг юм.

Өнөө цагт авилгал байгаа шалтгааныг олон талаар тайлбарладаг ч зах зээлийн нийгэм руу шилжих үйл явц нь өөрөө доороос эхлэн задлах бус дээрээс эхлэн бүрэн эрх мэдлийг бөөгнөрүүлэн хуримтлуулсан явдал нь хуучны тогтолцоог идээ бээртэй нь хутгах нэгэн гол хүчин зүйл болгож өдгөө тэр нь усташгүй мэт дархлааг бэхжүүлж чаджээ.Энэхүү судалгааны зорилго нь бүрэн эрхийн хувиарлалт шилжүүлэлт нь хэрхэн явагдаж байгаа болон төрийн удирдлагийн арга барил нь ямархуу түвшинд байгаа болон ашиг сонирхлын зөрчилдөөн хаанаас үүдэж байгаа болон цаашид анхаарах шийдвэрлэх ёстой арга замуудыг эрэлхийлсэн болно.

Авилгал нь тухайн этгээдэд янз бүрийн байдлаар ашиг тусаа өгдөг учраас оршин тогтносоор байдаг.Тухайлбал нэг улсад ямарваа нэгэн бичиг баримтыг хурдан гаргахыг хүсвэл иргэд тодорхой хэмжээний авилгал өгөх шаардлага гардаг гэж төсөөлье нэг талаас цаг хугацаа өөрөө үнэтэй учир зарим иргэд нь авилгал өгнө , хэдий үр дүн нь хувь хүн , нийгэм , пүүсд ашигтай байж болох ч тэд цагийг өөрийн хүсэл сонирхолдоо нийцүүлж өөрчилж чадаж байна. Хэрэв энэ нь цааш даамжирч гаарвал нийтийнэрхашгийг хөндөж эхэлдэг.

Жишээлбэл хууль бус аргаар олсон мөнгийг зах зээлд нь шингээж эргэлдүүлэх хүслээ түшмэлээр дамжуулан авилгалдаж хөрөнгө оруулалт хийж энэ нь зах зээлд ихээхэн байр суурыг эзэлж байвал энэ маш том аюул юм иймд цаашид гарах үр дагаврыг багасгах үүднээс зохих арга замуудыг нэн даруй өөрчлөх шаардлагатай.

Бүрэн эрх гэж юу вэ:

Аливаа байгууллага нь өөрийн онцлог байдлаас шалтгаалан өөрийн бүтцийг бий болгон бүрэн эрхийг олгодог. Бүрэн эрхийг тухайн хүнд ажил үүргээ гүйцэтгэх явцад нь шаардагдах эрх мэдэл бөгөөд жишээлбэл санхүүгийн менежер хүн тооцооны нягтлан бодогчоос ажил гүйлгээг нэгтгэсэн байдлаар гаргахыг шаардах бүрэн эрхтэй харин үндсэн үйлдвэрлэлийн цехийн мастериийг шууд болон шууд бус байдлаар удирдах эрхгүй байдаг. Бүрэн эрхийг хэрхэн ашиглахаас хамааран гүйцэтгэл ихээхэн шалтгаалдаг бөгөөд хэрэв буруу ашиглавал мөн өөрийн ашиг сонирхлыг харгалзан үзвэл авилгал хэрхэн бий болдог жишээг харуулахыг зорьсон болно.

Бүрэн эрхийн хувирлалт гэж юу вэ:

Бүрэн эрх нь төлөөлөн шилждэг мөн төлөөлөн шилждэг байх албагүй юм. Бүрэн эрхийг төлөөлөн шилжих байдлаар мөн хамааруулан тодорхой болон үндсэн бүрэн эрх гэж ангилдаг. Үндсэн ба тодорхой бүрэн эрх шилжиж болдог бөгөөд харин онцгой бүрэн эрх нь төлөөлөн шилждэггүй. Жишээлбэл : Монгол Улсын Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагч , өршөөл үзүүлэх, цол зэрэг олгох гэх мэт. Бүрэн эрх нь тиймээс хувь хүнд биш зөвхөн албан тушаалд олгогддог эрх мэдэл юм. Энэ нь албан тушаалтан ямар нэгэн хувийн эрх ашгийг харгалзан үзэлгүй нийтийн эрх ашгийн төлөө шийдвэр гаргах үүрэгтэй гэж ойлгож болно.

/Энэхүү онолын дагуу авч үзвэл МУ-ын төрийн өмчит байгууллага нь Шугаман ба Штабан бүрэн эрхтэй байна гэж авч үзсэн ./

Штабан бүрэн эрхийн бүтцийн бүдүүвч зураг/Сонгино хайрхан дүүргийн жишээ/



Шугаман удирдлагын шийдвэрийг няцаадаг байх эрх мэдлийг аппаратдаа олгодог жишээ бий .Шугаман удирдлагийн функцийн дутуу хэсгийг нөхөх эрх нь аппаратд байдаг. Жишээлбэл дүүргийн ИТХ хурлаас санал болгосон төсөл төсвийг засаг дарга

бататгах ,батлах эсэх нь өөрт олгогдсон бүрэн эрх бөгөөд бас давхар хяналтын аппаратыг гүйцэтгэх үүрэгтэй мөн ИТХ нь засаг даргийн ажил хэргийг үнэлэх хэлэлцэх бүрэн эрх олгогдсон байдаг гэтэл энэхүү үүргээ биелүүлэлгүй хувийн эрх ашгийн үүднээс шийдвэр гаргасан жишээг авч үзье.

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ч.Сайханбаярыг огцруулах санал гаргажээ

Эх сурвалж :

[/http://www.dailynews.mn/?vfile=5&vmet_id=10392&vmet_main=1660&vt=archive&vl=archive&vdate=&vofile=5&left=yes&vpage=200](http://www.dailynews.mn/?vfile=5&vmet_id=10392&vmet_main=1660&vt=archive&vl=archive&vdate=&vofile=5&left=yes&vpage=200)

Сонгинохайрхан дүүргийн ИТХ өнгөрсөн арванхоёрдугаар сарын 28-нд эхэлжээ. Энэхүү хурлаар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга С.Баярт болон засаг дарга Ч.Сайханбаяр нарын ажлын тайланг хэлэлцсэн байна. Хуралд МАХН-ын 31, Ардчилсан намын дөрвөн төлөөлөгч оролцож эцэст нь дүүргийн Засаг дарга Ч.Сайханбаярыг огцруулахаар шийджээ. Түүнийг огцруулах саналыг нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаярт өргөн барихаар болсон байна. Засаг дарга Ч.Сайханбаяр нь ажлын тайландаа хийгээгүй ажлаа хийсэн болгож, бусдын хийснийг өөрийн болгож оруулж иргэдийн төлөөлөгчдийг хуурсан хэмээн үзжээ. Мөн түүнийг огцруулах долоон үндэслэлийг дурдаж тус дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэр бүхий 14 төлөөлөгч гарын үсгээ зурж дүүргийн ИТХ-ын дарга С.Баяртад өргөн барьжээ. Тэд тэрхүү долоон үндэслэлдээ "Ч.Сайханбаяр нь өөрөө хуурамч дипломтой хэрнээ төрийн албаны дадлага тушлагатай ажилчдыг өөрийн өнгө үзэмжээр ажлаас нь халсан тухай дурджээ. Мөн Ч.Сайханбаяр Засаг дарга болсноос хойш Сонгинохайрхан дүүргийн ажил урагшаа ахиагүй зэрэг олон үндэслэл тоочсон байна. Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд ийм санал гаргаснаас хойш Засаг дарга Ч.Сайханбаяр ажилдаа ирэхгүй зугтсаар байгаа аж.

Тайлбар дүгнэлт:

Тухайн дүүрэгт засаг дарга байнга солигдож байдаг бүрэн эрх төлөөлөн шилжих боломжтой албан үүрэг бөгөөд харин засаг даргийн ажлын гүйцэтгэлийг 1-2 жил ажилласны дараа гүйцэтгэлийг үнэлэх хэрэгтэй байсан.Гэтэл 2-3 сарын ажлын үр дүнг хэлэлцэн ажлаас чөлөөлөх үндэслэл гаргах боломжгүй юм.Энэ үед МАХН –ын 32 гишүүн иргэдийн төлөөлөгчийн суудалд сууж АН –аас 4 –н төлөөллөл байж.Өөрөөр хэлбэл ИТХ –ын олонхи нь шийдвэр гаргах бүрэн эрхтэй ч тэдний шийдвэр нь нийтийн эрх ашиг бус хувийн болон намын эрх ашгийн үүднээс шийд гаргасан хэмээн үзэж болох үндэслэлтэй юм.

Шийдвэрлэх арга зам:

Засгийн газрыг ямар нам эвсэл барьж байгаагаас улбаадан тухайн төрийн бүх аж ахуй нэгжийг тэр намын гишүүд л удирдах эрхтэй мэтээр ойлгож ханддаг хандлага гарсан билээ.Хуулийг заалтаар МУ-ын иргэн ИТХ нэр дэвших эрхтэй байдаг ч төдийлэн энгийн иргэд нэр дэвшиж ялах үзэгдэл нь ховор байдаг. Энэ нь нийт төрийн тогтолцооны хяналтын системийн нэг бүр устгах авгилгалдах үндсэн алхам болж өгдөг.Яг чухам ямар хүчин зүйлүүдээс энэхүү алхам бий болж байгааг судлахад тун бэрхтэй байж болох ч асуудлын шийдлийг бид бүхэнд өгч чадна гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү жишээнээс авч үзвэл төрийн удирдлагийн механизм нь өөрөө буруу бөгөөд авилгалын хэмжээ их байгааг харж болох юм.Менежментийн онолын үүднээс Ардчилалын эрх тэгш байх зарчмын дагуу үйл ажиллагаа нь явагдаж буй мэт боловч эцсийн дүгнэлт бол энэ нь шударга бус тогтолцоо байгааг харуулж байна.Статистикийн тоо баримтаас авч үзвэл нийт ажиллах хүчний **62.3**хувь орчим нь залуучууд эзлэдэг бөгөөд гагцхүү тэд маань хувийн хэвшлийн байгууллага биш төрийн албанд орох сонирхолтой байдаг нь нууц биш юм.

Цааш үргэлжлэх судалгааны хэсэгт маань Монгол улсын инфляцын түвшин болоод цалингийн өсөлт нь ард иргэдийн амьдралд хүрэлцэхүйц байж чаддаг уу эсвэл үгүй бол энэ нь албан тушаалтны авилгал авах шалтгаан болж байна уу гэдгийг судалж үзнэ.Эдийн засгийн үүднээс далд эдийн засгийг нарийн судлах боломжгүй учир цалингийн өсөлт нь яалангуяа төрийн албаны цалин хүрэлцдэггүйн улмаас авилгал авах шалтгаан болж байгаа эсэхийг судалсан болно.

Судалгааны хэсэг:

I Хүснэгт .Төрийнавилгач тогтолцооны төрлүүд

Хахууль авагчид	Олон тоотой хахууль өгөгчид	Цөөн тоотой хахууль өгөгчид
Засаг төрийн дээд зиндааныхан дотор	Клепроткрат: а)Хахууль шаарддаг төр б)Хүчгүй төр	Хоёр талтай монополиуд
Засаг төрийн доод Зиндааныханы дотор	Мушгирсан маягийн өсөлтийн нөөцтөй өрсөлдөөнт хахуултдалт	Мафийн улс

Клептократ

Луйварчин дарангуйлагч маш олон тоотой зохион байгуулалтгүй боломжийн хахуульдагчтай тулгардаг нөхцөл байдлыг авч үзье.Онцгой тохиолдолд төрийн хүчтэй тэргүүн сул ашиг.(түрээсээр)

1 <<Клептократ>>хэмээх нэр томъёо анх Andreski (1968 онд)хэрэглэж хувьдаа баяжих хөлжихийг нэн тэргүүнээ тавьдаг , төрийн албан тушаалаа далимдуулан авилга авах зорилгоо хэрэгжүүлдэг зорилгоо хэрэгжүүлэх хангалттай эрх мэдэл бүхий улс орны удирдагч юм уу засгийн газрын өндөр албан тушаалтанд хамаарах нэр томъёо болгон хэрэглэжээ.

Жишээлбэл эдийн засгийн экспортийг бий болгодог гол сектор төрийн мэдэлд байвал төрийн тэргүүн нь хөдөлмөрийн өндөр бүтээмж ,үйлдвэрлэлийн үр ашгийг улам нэмэгдүүлдэг хөлслөх,албан тушаал өсгөх тийм системийг дэмжин өөгшүүлэх болно.Гэхдээ Клепократуудын дийлэнхи нь олсоны томъёолсон суурин дээрэмчид шиг бүхнээс хүчтэй биш байдаг .Тэд дээд зэргээр хувьдаа боломжийн хэрээр баяжих зорилготой авч уг зорилгодоо арга хэрэгсэл нь дэндүү болхи бүдүүлэг байдаг байна .Тэд төрийн машиныг хянадаг ч төрийг бүхэлд нь удирдаж чаддаггүй.

Хоёр талтай монополиуд , мафийн улсууд

Хувийн хүчтэй ашиг сонирхол төрд нөлөөлөхийн зэрэгцээ авилгалын түлхээсийг сөрж чаддаг хоёр тохиолдлыг одоо авч үзье.Эдгээр тохиолдолд тухайн аль нэг улсад хахуулийн тогтолцоо төвлөрсөн эсэхээс хамааран заагтай ялгаатай байдаг.

Эхний тохиолдолд авлигач удирдагч ганцхан гол аргачтай сөргөлдөгчтэй тулгардаг.Хоёр талтай монополютой (bilateral monopoly)энэ нөхцөлд рент авах боломжийг хахууль өгөгч ,удирдагч хоёр л хоорондоо хуваан хувиарлаж авдаг.Тэдний харьцангуй хүч ,нөлөө хувийн ашиг хонжоогоо хуваах арга барилыгтодорхойлно.Үүнээс бялууны нийт хэмжээ ч шалтгаална.Зарим төрлийн рентийг улсын дэмжлэгтэй бий болгох аваас удирдагч өртөй нь арцагч бүх юмыг булаан авчихна гэж болгоомжлоод ямар нэг сайжруулахаар оролдон зүтгэж ,эсрэг талдаа хохирол учруулж жишээ нь нэгтээгүүр өмчийг нь булааж авах ,нөгөөтэйгүүр хүч хэрэглэх зэргээр үргэлжилдэг.

Өрсөлдөөнт хахуульдалт


Ийм үед доод шатны өдий төдий түшмэд ард иргэдийн өргөн давхраатай хамтран ажилладаг.Дурдсан тохиолдолд байдагчлан ардчилсан засаг төртөй улсад ч ийм нөхцөл

байдал байж болдог, ийм улсад авилгын сулхан хянаж ,төрийн албан хаагчид нийгмийн өмнө ажлаа тайлагнах журам хөгжөөгүй байдаг .Түүнээс гадна иймэрхүү байдал ганц хүн дангаараа захирдаг сулхан дэглэмийн нөхцөлд нийтийн үйлчилгээ үзүүлэхэд бий болж мэднэ.

Өрсөлдөөнт авлига нь өрсөлдөөнт зах зээлтэй огтхон ч адилгүй.Энэ тохиолдолд авлигийн доод шатнаас дээд тал руу нь түүнийг мушгируулан эрчлэх боломж гол суурь асуудал болдог .

Монгол улсын хувьд

Нийт тогтолцооны хувьд гурван төрөл нь засаглалын аль ч секторт оршиж байгаа юм.Учир нь авилын индексээр Монгол улс тэргүүлэх эгнээний байр сууриндаа хэвээр байгаа.Энэ индексд орж буй орнууд ихэвчлэн хөгжиж буй орнууд байдгаас гадна төрийн тогтолцоо нь шударга бус илтгэдэг.Мушгирсан зангилаа бүхий доороос дээш өгссөн авилгийн тогтолцоо дархлаагаа бий болгож төрийг хангалттай залуурдаж чадахаар хүчтэй болжээ.



/Гүн улаан байх тусмаа авилгалд ихээр автагдсан ,гэрэлтэй шар бага байх тусмаа авилгал багатай байгааг илэрхийлнэ/

Бага цалин ба инфляци нь авилгийн эх үндэс болох нь

Цалин гэж ямар нэгэн компани болон бусад байгууллагуудад хувь хүн өөрийн хөдөлмөрөө худалдаад оронд нь авч буй мөнгө билээ. Цалинг бизнэсээс олох ашигтай харьцуулахад нэг дутмаг чанар нь тухайн хүний хэчнээн хүч хөдөлмөр сэргэлэн ухаан зарцуулснаас үл

хамааран тогтмол дүнтэй байдаг. За ер нь цалин нь их олон зүйлээс хамаарч байдаг. Төрийн албан хаагчдын цалин өсөх (өрхийн цалин болон орлого нэмэгдэх) нь инфляцийг өсгөх шалтгаан болдог уу, эсрэгээр нь инфляци өндөр байх нь цалин болон орлогыг өсгөх шаардлага бий болгож байна уу гэсэн асуултаудын хариулт нь маргаантай байсаар байгаа бөгөөд үүний хариултыг шалган тодорхойлох нь чухал байна.

Төрийн албан хаагчдын цалин өсөх нь боловсон хүчний шилжилтийн болгоомжлол, инфляцийн бага зэргийн өсөлтөөр дамжин хувийн хэвшилд ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх шалтгаан болох бөгөөд энэ тохиолдолд нийт өрхийн цалин болон орлогын өсөлт нь нийт эрэлтийг өсгөн улмаар илүү өндөр инфляцийн шалтгаан (demand driven inflation)-ыг бий болгох талтай.

Ийм үүднээс энэхүү судалгааны зорилгоор цалин нь инфляци, хэрэглээний үнийн индексээс хэрхэн хамаарч байдаг мөн хангалтгүй цалин нь ба үнэгүйдэл нь авилгал үүсэх шалтгаан мөн үү гэдгийг судлахаар шийдлээ.

Тодорхойлолт

Инфляци: гэдэг нь тухайн улс оронд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээнээс гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ хэтэрсэн нөхцөлд үүсдэг мөнгөн ханшийн үнэгүйдэл юм. Инфляци нь үнийн хэт өсөлтөөр илэрдэг бөгөөд түүнийг хэмжихдээ жилийн хэрэглээг тодорхойлж чадах багц бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлтөөр тодорхойлдог. Үнийг дээрээс (засгийн газраас) хатуу тогтоовол бараа үйлчилгээний хэмжээ хомсддог, хатуу үнийг чөлөөлбөл бүтээгдэхүүний үнэ өсч инфляци хүчтэй явагдаж эхэлдэг. Инфляцийн түвшин нь эдийн засаг хөгжих тогтворжих эс тогтворжихын гол нөхцөл учраас үүнийг засгийн газрууд эдийн засаг, нийгмийн бодлогынхоо гол бүрдэл болгон байнга анхаарч байдаг. Монгол улс зах зээлийн тогтолцоонд шилжих үеэс үнийг чөлөөлж, инфляцийн үзэгдэлтэй анх тулгарч, тэр тухай ойлголт нь гүнзгийрэн, улмаар түүнийг хязгаарлах, бууруулах бодлого явуулсан. Инфляци нь 2 үндсэн шалтгааны улмаас үүсдэг. -эрэлтээс үүдэлтэй -нийлүүлэлтээс үүдэлтэй гэж ангилдаг. Эрэлтээс үүдэлтэй инфляци гэдэг нь хүн ам, айл өрхийн өсөн нэмэгдэж буй төлбөрийн чадвартай эрэлтээс санал болгосон үйлдвэрлэл, үйлчилгээний тоо хэмжээ хоцрох явдал юм. Энэ үед дэлгүүрийн лангуу хоосрох, хүмүүс ямар ч хамаагүй барааг авч “дарах” явдал илтэд ажиглагддаг. Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляци гэдэг нь үйлдвэрлэл, үйлчилгээний зардал ихсэх эсвэл тэдгээрийн нийлүүлэлтийн механизм гажилттай болсноос үүдсэн инфляци юм. Энэ үед үйлдвэрлэлийн цалин, үндсэн түүхий эдийн үнэ “огцом” өсөх үндсэн дээр бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг нэмэгдсэнээс үүсэлтэй инфляцийг бий болгодог. Инфляцийг үнийн индексээр хэмждэг.

Хэрэглээний үнийн индекс: Энэ хэмжээслэл нь инфляцийн түвшинг илэрхийлэх болон нийгэм хамгаалалын хөтөлбөрийн өөрчлөлтийг гаргахад засгийн газрын ашигладаг хүчин

зүйл юм.ХҮИ нь хотын ердийн хэрэгчлэгчдийн худалдан авсан зах зээлийн сагсны нийт үнүүдийн харьцаа юм.

ХҮИ =(тодорхой жилийн хамгийн өргөн хэрэглээний зах зээлийн сагсны нийт үнэ / суурь жилийн ижил зах зээлийн сагсны үнийн тооцоо) X 100% гэж олдог.

Судалгааны хэсэг

Энэхүү судалгааг 1984-2006 оны сар болгоны мэдээлэл (2-дагч өгөгдөл) дээр суурилан хийсэн болно. Сонгосон учир нь энэхүү жилүүдэд дотоодын нийт бүтээгдэхүүн болон улсын төсөв ашигтай гарч байсан үеүд юм.

Үр дүнгийн хувьсагч (y) нь wage буюу цалин

Хүчин зүйлийн хувьсагчид нь inflation=inflation буюу инфлаци

cpi=cpi буюу хэрэглэгчийн үнийн индекс

а.Олон хүчин зүйлт регрессийн тэгшитгэл үнэлэх нь

Хавсралт 1-ийг ашиглан цалин болон инфлаци, хэрэглэгчийн үнийн индексийн тэгшитгэлийг үнэлэн гаргаж ирлээ.

$$WAGE = -0.8810229961 + 0.008233799681*INFLATION + 0.0858145316*CPI$$

$$b1=-0.8810229961$$

b2=0.008233799681 инфлацийн хэмжээ 1 нэгжээр буюу 0.008233799681-р нэмэгдэхэд цалин дээрх хэмжээгээр нэмэгдэж байна. Үүнээс үзэхэд инфлацийн хэмжээ нь цалинд шууд эерэгээр нөлөөлж байна.

b3=0.0858145316 хэрэглэгчийн үнийн индексийн хэмжээ 1 нэгжээр буюу 0.0858145316 -р нэмэгдэхэд цалин дээрх хэмжээгээр нэмэгдэхээр байна. Эндээс харахад хэрэглэгчийн үнийн индекс нь цалинд шууд эерэгээр нөлөөлж байна.

б.Регрессийн тэгшитгэлийн стандарт алдаа(σ)-г тооцох нь

Регрессийн тэгшитгэлээр гарган авч байгаа \hat{y}_i үнэлсэн (онолын) утгуудын найдвартай эсэх нь ихэнхдээ регрессийн шугамын ойролцоох ажиглалтын утгуудын сарнилтаар

тодорхойлогдоно. Энэхүү сарнилтын их, багыг үзүүлж буй хэмжигдэхүүнийг регрессийн тэгшитгэлийн стандарт алдаа гэж нэрлэдэг.

Дээрх тэгшитгэлийн (онолын утгуудын) бодит утгаасаа хазайх хазайлт нь ойролцоогоор $\sigma=0.354815$ байна.

с.Детерминацийн коэффициент(R²) тооцох нь

Детерминацийн коэффициент гэдэг нь үр дүнгийн хувьсагч нь хүчин зүйлийн хувьсагчаас хэрхэн хамаарч байгааг илэрхийлсэн дээрх тэгшитгэл хэр зэрэг оновчтой, зөв сонгогдсоныг хэмждэг хэмжигдэхүүн юм. Детерминацийн коэффициент нь 0-с нэгийн хооронд утгаа авах бөгөөд хэдий чинээ нэг рүү тэмүүлнэ, төдий чинээ уг сонгосон загвар оновчтой байгааг илтгэнэ.

Дээрх тэгшитгэлийн хувьд детерминацийн коэффициент нь $R^2=0.979118$ ($\tilde{R}^2=0.978961$) байна. Эндээс үзэхэд хэрэглээний үнийн индекс болон инфляци нь цалинг дээрх тэгшитгэлийн тусламжтай 97%-ийг тайлбарлаж чадах бөгөөд үлдсэн 3% нь бусад хүчин зүйлийн нөлөөлөл байна.

Олон хүчин зүйлийн корреляцийн коэффициент тооцох нь

Үр дүнгийн хувьсагч ба хоёр болон түүнээс дээш тооны хүчин зүйлийн хувьсагчийн хоорондын шугаман хамаарлын хүчийг тодорхойлоход корреляцийн коэффициентийг ашигладаг. Корреляцийн коэффициентийг тодорхойлохын тулд эхлээд хосын корреляцийн коэффициентийг тооцох шаардлагатай бөгөөд эдгээр нь дараах байдалтай байна.

$R_{wage;infln}=-0.148767630498742$ (цалин болон инфляци хоёрын хооронд шугаман бус хамаарал байгаа бөгөөд инфляци нэмэгдэхэд цалин дунджаараа буурна)

$R_{wage;cri}=0.989503818652152$ (цалин болон хэрэглэгчийн үнийн индекс хоёрын хооронд шугаман хамаарал байгаа бөгөөд инфляци нэмэгдэхэд хэрэглэгчийн үнийн индекс дунджаараа өснө)

$R_{infln;cri}=-0.151047625295047$ (инфляци болон хэрэглэгчийн үнийн индексийн хоорондын хамаарал)

Инфляци хэрэглэгчийн үнийн индекс хоёр цалинд мэдэгдэхүйц нөлөөлдөг байна.

Цалин болон инфляци

Судалгааны хэсэг

Энэхүү судалгааг 1984-2006 оны сар болгоны мэдээлэл (2-дагч өгөгдөл) дээр суурилан хийсэн болно.

Үр дүнгийн хувьсагч (y) нь wage буюу цалин

Хүчин зүйлийн хувьсагчид нь $x_1 = \text{inflation}$ буюу инфлаци

а.Энгийн шугаман регрессийн тэгшитгэл үнэлэх нь

Хавсралт 1-ийг ашиглан цалин болон инфлаци, хэрэглэгчийн үнийн индексийн тэгшитгэлийг үнэлэн гаргаж ирлээ.

$$WAGE = 12.41284618 - 1.723329753 * INFLATION$$

$$b_1 = 12.41284618$$

$b_2 = -1.723329753$ инфлацийн хэмжээ 1 нэгжээр буюу -1.723329753 -р хасагдахад цалин дээрх хэмжээгээр хасагдаж байна. Үүнээс үзэхэд инфлацийн хэмжээ нь цалинд шууд сөргөөр нөлөөлж байна.

в.Корреляцийн коэффициент тооцох нь

Үр дүнгийн хувьсагч ба хоёр болон түүнээс дээш тооны хүчин зүйлийн хувьсагчийн хоорондын шугаман хамаарлын хүчийг тодорхойлоход корреляцийн коэффициентийг ашигладаг (Ч.Наранчимэг, Д.Ганзориг, 2009). Корреляцийн коэффициентийг тодорхойлохын тулд эхлээд хосын корреляцийн коэффициентийг тооцох шаардлагатай бөгөөд эдгээр нь дараах байдалтай байна.

$$r_{yx} = -0.148767630498742$$

(Цалин болон инфляци хоёрын хооронд шугаман хамаарал байгаа бөгөөд инфляци нэмэгдэхэд улсын орлого дунджаараа багасна)

с.Регрессийн тэгшитгэлийн стандарт алдаа(σ)-г тооцох нь

Регрессийн тэгшитгэлээр гарган авч байгаа \hat{y}_i үнэлсэн (онолын) утгуудын найдвартай эсэх нь ихэнхдээ регрессийн шугамын ойролцоох ажиглалтын утгуудын сарнилтаар тодорхойлогдоно. Энэхүү сарнилтын их, багыг үзүүлж буй хэмжигдэхүүнийг регрессийн тэгшитгэлийн стандарт алдаа гэж нэрлэдэг.

Дээрх тэгшитгэлийн (онолын утгуудын) бодит утгаасаа хазайх хазайлт нь ойролцоогоор $\sigma = 0.701042696948179$ байна.

d. Детерминацийн коэффициент(R²) тооцох нь

Детерминацийн коэффициент гэдэг нь үр дүнгийн хувьсагч нь хүчин зүйлийн хувьсагчаас хэрхэн хамаарч байгааг илэрхийлсэн дээрх тэгшитгэл хэр зэрэг оновчтой, зөв сонгогдсоныг хэмждэг хэмжигдэхүүн юм. Детерминацийн коэффициент нь 0-с нэгийн хооронд утгаа авах бөгөөд хэдий чинээ нэг рүү тэмүүлнэ, төдий чинээ уг сонгосон загвар оновчтой байгааг илтгэнэ.

Дээрх тэгшитгэлийн хувьд детерминацийн коэффициент нь $R^2=0.022132$

($\tilde{R}^2=0.018469$) байна. Эндээс үзэхэд инфляци нь цалинг дээрх тэгшитгэлийн тусламжтай 2%-ийг тайлбарлаж чадах бөгөөд үлдсэн 98% нь бусад хүчин зүйлийн нөлөөлөл байна.

Дээрх хэд хэдэн судалгааны үр дүн, дүгнэлтээс харахад эдгээрийн хооронд хамаарал байгаа нь ажиглагдаж байна. Цалин инфляци болон ХҮИ-ээс эерэг хамаарч байна. Инфляци ХҮИ нь тус бүр хоорондоо мультиколлеанарын асуудалтай, өөрөөр хэлбэл эдгээр нь хоорондоо ямар нэгэн шугаман хамаарлаар шууд хамаарч байна.

Харин дээрх судлагдсан утгуудын хооронд автокорреляци буюу хугацааны (жилийн) хоцрогдол байхгүй байгааг харж болно.

Монгол улсын инфляцын түвшин дунджаар жилд 6.7 хувь орчим өсдөг гэж үзвэл цалин нь мөн дагаж өсөж байна гэсэн үг энгийн төрийн албан хаагч нь сард 350000-870000 орчим төгрөгний цалин авдаг бөгөөд албан тушаалаас хамаарч өөр өөр байдаг. Энэхүү цалинг монгол улсын ДНБ тэй харьцуулж үзвэл хангалтгүй дүн бөгөөд цааш илүү их мэдээллэлээр судлан үзвэл бага цалин авдаг нь авилга авч болох нэгэн зайлшгүй шалтгаан болж байгааг энэхүү судалгаанаас харж болно.

Дүгнэлт хэсэг

Төрийн байгууллагын бүрэн эрхийнхувиарлалт нь тэгш бус байгаа нь хяналтын системийн үгүй болгож байгаа юм.Хэрэв бүтцийн хувьд өөрчлөлт хийвэл хяналтын аппарат нь өөрчлөгдөх гарц бий болно.Эхний жишээн дээр хэрэв дүүргийн ИТХ ын зөвлөл нам бус ямар нэгэн сонирхлын болон албан бүлэгт харьяалагдаггүй байсан бол хяналтын аппарат нь сайн ажиллаж хяналтын үүргийг сайн гүйцэтгэж чадах байсан.

Гэхдээ парламентийн тогтолцоотойгоо яг адил бүтцийг бүх төрийн байгууллагад олонхийн саналаар гүйцэтгэлийн шийдвэрийг гаргадаг арга барилыг бий болгоод байвал ашиг сонирхлын зөрчилдөөн нь хэзээ ч төгсгөл болохгүй юм.Мөн иргэдийн орлогийн түвшин ажлын цагын хувиар нь дүүргийн хорооны дарга нартай уулзах нийгмийн ажилд хяналт тавих явцыг бий болгохгүй байгаа юм.Энийг илүү ёс зүйн ухамсартай холбон тайлбарлавал үр дүнд хүрч болох юм.

Авилгалтай төрийн гурван бүтцийг монголын улс төрийн нөхцөлтэй харьцуулан үзэхэд тохирч байгаа бөгөөд хэрэв авилгалын индексийн үзүүлэлт өндөр байгаа бол энэ бүх үзүүлэлттэй таардгийг бид авч үзсэн билээ.Энэ бүх систем ард иргэдэд үр өгөөжөө өгдөггүй ашиг үр дүнгүй зүйлүүд ихээхэн гардаг.Тухайлбал Өмнөд Солонгос улсад нэгэн эмнэлэгийн барилга нь өөрөө нуран сүйджээ.Барилгийн зөвшөөрлийг өгсөн түшмэд авилгал авч чанаргүй барилга барих зөвшөөрлийг өгсөн.Энэ гурван түвшинд авилга нь улс орны бүхий л салбар нэгжил нөлөөлдөг болох нь батлагдаж байгаа юм.

Мөн цалингийн бага хүрэлцээгүй байдал нь энгийн авилгач бус албан тушаалтанд авилгалд өгөх үндсэн сэдэл болж байж болзошгүйг хэрэглээний үний индекс болон цалингийн өсөлт ,инфляцын түвшингийн өсөлттэй харьцуулсан судалгааг авч үзсэн билээ.Шийдвэрлэх арга замын нэг нь цалин хангамжийг өсгөх байж болохоор байгаа юм.Энэхүү асуудлуудыг шийдвэрлэж чадвал бага ч гэсэн хувь нэмрийг шударга үйлст зориулах юм.

Ном зүй ашигласан материал:

Авилгал төр хоёр /Сьюзан Роуз Аккерман/, Зууны мэдээ сонин, Авилгал мөнхийн үзэгдэл биш /Ч.Энхбаяр/, Авилгын эсрэг сурвалж бичиг /Ж.Поуп/ Үндэсний шударга ёсний тогтолцоо үзүүлэлтүүд /Д.Жавзансүрэн/, Монгол улсын статистикийн эмхтгэл 2010 он /Үндэсний статистикийн хороо